# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр Дугаар А/447 Номгон

Иргэн Ж.Төмөрбаатарын эзэмшил газрын
зөрчил арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Ж.Төмөрбаатарын (ШЖ65022875) Үйлчилгээтэй орон сууцны зориулалттай 2408 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул илүү эзэмшиж буй 116 м2 газарт дуудлага худалдааны анхны үнэ дээр дуудах нэг удаагийн интервалыг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, газрыг нэмж эзэмшүүлэн хавсралтаар батлсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Ж.Төмөрбаатарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

601210037

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын
09-ний өдрийн А/447 дугаар захирамжийн хавсралт

ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| д/д | Газар эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт | Хаяг | Талбайн хэмжээ /м2/ | Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ж.Төмөрбаатар | ШЖ65022875 | 6409008602 | Үйлчилгээтэй орон сууц | Баянхонгор сум, Номгон 1-р баг, Чандмань-1 гудамж, 119 тоот | 2408 м2 | 116 м2 | 2292 м2 |

-------------------oOo-----------------